

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН СҮЛД ЧУУЛГЫН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2019 оны 06 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Тус чуулгаас төрийн хууль тогтоомж, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн “Удирдлагын манлайлал, алба хаагчдын сахилга хариуцлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх” зорилт, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, албан даалгавар, үүрэг, чиглэл, ЦБҮАЖ, дүрэм, холбогдох бусад эрх зүйн актуудыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ 2019 оны I улиралд нийт 61, II улиралд нийт 49 ажил, арга хэмжээг чуулгын хэмжээнд төлөвлөж, гүйцэтгэлийг ханган ажиллалаа.

Нэг. Удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн талаар

Чуулгын бие бүрэлдэхүүний өдөр тутмын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангахтай холбоотойгоор чуулгын даргаас нийт 10 удаа, давхардсан тоогоор 63 алба хаагчид 231 үүрэг, даалгавар өгч биелэлтийг бичгээр авч, оноот баллын үзүүлэлтээр үр дүнг тооцож ажиллаж байна.

Даргын зөвлөлийн хурлыг 7 удаа хийж хүний нөөцтэй холбоотой 17, үйл ажиллагаатай холбоотой 3, нийт 20 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, хүний нөөцийн чиглэлээр 38, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 10, нийт 48 тушаал гаргаж, алба хаагч, ажилчдаас 25 өргөдөл хүлээж авснаас ажилд орох, суралцахыг хүссэн 7, захиргааны чөлөө хүссэн 11, бусад 8 өргөдлийг хүлээж авч шийдвэрлэсэн.

375 албан бичиг гадагш явуулж, 453 албан бичгийг хүлээн авч, зохих журмаар шийдвэрлэж, 139 хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь өгч ажиллав.

ЦЕГ-ын дэд даргаас ирүүлсэн ЦЕГ-ын даргын 2019 оны 02 сарын 19 өдрийн тушаалаар батлагдсан “Итгэлцлийн гэрээ”-ний загварын дагуу чуулгын 63 алба хаагч, ажилтантай нэг бүрчлэн “Итгэлцлийн гэрээ”-г байгууллаа.

Байвал зохих офицер 12, ахлагч 45, энгийн 11, нийт 68 алба хаагч, ажилтнаас офицер 12, ахлагч 44, энгийн 11 алба хаагч, ажилтан ажил, үүрэг гүйцэтгэж, одоогийн байдлаар бүжигчний 2 орон тоо дутуу байгаа болно.

Чуулгын даргын тушаалаар 6 алба хаагч, ажилтныг томилж, 1 алба хаагчийг чөлөөлж, 3 алба хаагчид чөлөө олгож, 1 алба хаагчид цагдаагийн цол олгосон байна.

Чуулгын сул орон тоог нөхөх зорилгоор 5 иргэнийг судалж, 3 иргэний материалыг ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж, хөдөлмөрийн гэрээ байгуулан туршилтын хугацаагаар томилох зөвшөөрөл авсан болно.

Чуулгын даргын 2019 оны тушаалаар “Чуулгын төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн гэрээг үнэлэх дүгнэх журам”, “Төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн гэрээг сар, улирал жилээр дүгнэх оноот баллын үзүүлэлт”-ийг чуулгын даргын тушаалаар баталж, алба хаагч нэг бүрийн ажлыг хагас жилээр дүгнэж байр эзлүүллээ.

2019 оны эхний хагас жилийн ажлын үр дүнгээр чуулгын хэмжээнд 63 алба хаагч, ажилтнуудын ажлыг үнэлсэн бөгөөд “бүрэн хангалттай” - 26, “хангалттай”- 31, “хангалтгүй”- 0, дүгнэгдээгүй- 6 алба хаагч, ажилтны ажлын үзүүлэлт бүрэн дүгнэгдэх боломжгүй байна.

Чуулгын хэмжээнд бүжгийн багш, дэглээч, туслах найруулагч, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгар 112.5 оноогоор I байр, Соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг 99.5 оноогоор II байр, дуучин, цагдаагийн ахлах ахлагч Г.Дарханбаатар 98.83 оноогоор III байр, жижүүрийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Г.Очироо 98.66 оноогоор IV байр, төлөвлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ч.Бадамдорж 98 оноогоор V байранд тус тус шалгарсан.

Чуулгын 12 офицер алба хаагчдын ХАСХОМ-ыг мэдүүлж баталгааны хуудсыг хэвлэн тайлан, мэдээний хамт 2019 оны 02 дугаар сарын 15-ны дотор хуулийн хугацаанд Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлж танилцуулсан байна.

Чуулгын өргөдөл гомдлын мэдээ болон захиргааны зөрчлийн мэдээнүүдийг сар бүрийн 25-наар тасалбар болгон холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэв.

2019 оны ээлжийн амралтын хуваарийн дагуу хагас жилийн байдлаар 5 алба хаагч ажилтан ээлжийн амралтаа эдэлсэн байна.

ЦЕГ-ын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст 24/351 дугаартай албан бичгээр 20 албан тушаалын тодорхойлолтын төслийг шинэчлэн боловсруулж хүргүүлсэн.

Мөн Төрийн албан хаагчийн анкет шинэчлэгдсэнтэй холбоотойгоор алба хаагчдаар анкетыг шинээр бөглүүлж, ахлагч алба хаагчдыг хувийн хэрэгт хийж, офицер алба хаагчдын анкетыг ЦЕГ-ын ХНХ-т хүргүүлсэн.

2018 онд чуулгаас чөлөөлөгдсөн 7 алба хаагчдын албаны үнэмлэх, энгэрийн тэмдэгийг жагсаалтаар гаргаж ЦЕГ-ын ХНХ-т албан бичгээр үнэмлэх хариуцсан мэргэжилтэнд хураалгав.

Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Бат-Өлзий, Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Долгорсүрэн, Хүний нөөцийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Ж.Баясгалан нар Чуулгын 25 алба хаагчтай уулзаж, үйл ажиллагааны ололт, амжилт, бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх ажлын талаарх санал сэтгэгдлийг сонссон болно.

Чуулгын даргын 2019 оны тушаалаар “2019 оны хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-аар 31 баримт бичгийн 43 заалтын жагсаалтыг баталж, хариуцахаар тусгасан алба хаагчид хэрэгжилтийг ханган хагас жилийн байдлаар хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, тайланг гаргаж холбогдох алба, газар, хэлтсүүдэд хүргүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 46 дугаар захирамжаар баталсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажилд улсын үзлэг”-т бэлтгэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангахын зэрэгцээ 2017 оны баримт бичгийг цахимжуулах ажлыг зохион байгуулав.

Эхний хагас жилд хөгжимчин, цагдаагийн дэд ахлагч Б.Мягмарбүрэнхүүд ХНСХ-ийн зөвшөөрлийг үндэслэн урьд хэрэглэж байсан “Цагдаагийн ахлагч” цолыг олгож, чуулгын дарга, цагдаагийн хурандаа Л.Гаваасүрэн нь “Монгол Улсын Соёлын Гавьяат зүтгэлтэн”, найруулагч, цагдаагийн дэслэгч У.Оюунномин нь МУ-ын Ерөнхийлөгчийн 2019 оны 14 дүгээр зарлигаар “Цэргийн хүндэт медаль”-иар, хөгжимчин, цагдаагийн ахлах ахлагч У.Батбаяр БСШУСЯ-ны “Жуух бичиг”-ээр тус тус шагнагдлаа.

Хоёр. Сахилга хариуцлагыг төлөвшүүлэх, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар

Сургалтын чиглэлээр: 2019 оны хагас жилд чуулгын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх 19 удаагийн 38 цагийн сургалтыг давхардсан тоогоор 646 алба хаагч, ажилтнууд хамруулан зохион байгууллаа.

Тухайлбал, мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтын хүрээнд ХСИС-ийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахмад багш, цагдаагийн бэлтгэл хурандаа С.Бямбаа “Цагдаагийн алба хаагчийн харилцааны ёс зүй”, чуулгын Төлөвлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Ч.Бадамдорж “Гэмт хэрэг зөрчилд холбогдсон гадаадын иргэнтэй харилцах”, “Согтууруулах, мансууруулах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль”, ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн хошууч Бямбадорж “Цагдаагийн албаны тухай хууль”, ЦЕГ-ын СААА-ны Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Л.Эрдэнэхорол “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль”, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын, Хөдөлмөр нийгмийн хамгаалал, тусгай хэлтсийн Хөдөлмөр хяналтын улсын байцаагч Г.Гантөмөр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”, Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Г.Алтан-Эрдэнэ “Авлигаас урьдчилан сэргийлэх”, чуулгын жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Ц.Ууганбаяр “Тусгай хэрэгсэл, агсамж хэрэглэх журам заавар” сэдвээр сургалт явуулав.

ЗГ-ын 2019 оны 01 сарын 23-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, 38 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-аар сургалт хийв.

Алба хаагчийг хөгжүүлэх сургалтын хүрээнд чуулгын цагдаагийн музей, соён гэгээрүүлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч С.Дуламсүрэн “Цагдаагийн байгууллагын түүх, үүсэл хөгжил”, Амар Оюуны Хөрөнгө Оруулалт ХХК-ийн захирал Ч.Сайханаа “Мэтгэлцээний тухай”, чуулгын дуучин, цагдаагийн ахлах дэслэгч Б.Долгормаа “Англи хэлний анхан шатны мэдлэг олгох” сургалт, Удирдлагын академийн багш С.Жаргалсайхан “Соёл урлагийн маркетинг”, ДХИС-ийн цагдаагийн сургуулийн дэд профессор, цагдаагийн хошууч Б.Баянмөнхийг урьж офицер алба хаагчдад зориулан “Хичээлийн конспект бэлдэх аргачлал” сургалтыг хийв.

Дадлагажуулах сургалтын хүрээнд Монгол Улсын ЗГ-ын 2011 оны 339 дүгээр тогтоолоор “Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх” журам, “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болгох тухай 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн пүрэв гаригт гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургалт хийж бэлэн байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах тухай ЦЕГ-ын ТЗБХ-ээс ирүүлсэн албан бичгийн дагуу Чуулгын хэмжээнд гамшгийн аюулын зарлан мэдээллийн үед нүүлгэн шилжүүлэлт хийх, аюулын дохиогоор ажиллах, албаны бэлэн байдлыг хангахад анхаарах асуудал зэргээр БЗД-ийн Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэн ахмад Должинсүрэнгээр дадлага, сургалтыг зохион байгуулав.

Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтын хүрээнд бүжигчин, цагдаагийн ахлагч Ө.Ичинхорлоо “Иогийн хичээл”, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч Н.Ганзүрх “Жагсаалын бэлтгэл”, “Хүч” спорт

хорооны Биеийн тамирын эмчилгээний арга зүйч, цагдаагийн ахмад Б.Даваасамбуу “Үйлдвэрлэлийн осол, гэмтэл болон эмнэлэгийн анхан шатны тусламж”, бие хамгаалах “Монгол Крав Мага” холбооны тэргүүн Б.Батжав “Зэвсэггүйгээр өөрийгөө хамгаалах нь” сэдэвт хичээл орсон.

Сургагч багш тус чуулгын соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиглэлээр үүрэг гүйцэтгэдэг хэсгийн байцаагч, эргүүлийн офицеруудад зохион байгуулсан Объект, субъектийн судалгаа хийх аога зүй, урьдчилан сэргийлэх ажилд ашиглах нь”, “Машинт эргүүлийн офицер, цагдаа нарын ур чадварыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтын хүрээнд “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” сэдвээр 58 алба хаагчдад 2 удаагийн 4 цагийн хичээл, “Олон нийтийн цагдаа бэлтгэх сургалт”-д 30 иргэнд 2 цагийн сургалтыг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу, “Хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх нь”, “Бидний харилцаа бие биеэ хүндлэхээс эхэлнэ” 110 сурагчдад 1 удаагийн 2 цагийн хичээл оров.

Тус чуулгаас алба хаагчдыг эрдэмжүүлэхэд онцгой анхаарч мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх сургалт хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан алба хаагчдыг дэмжиж, суралцах нөхцөл бололцоогоор ханган ажиллаж, Хууль сахиулахын их сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу “Цагдаа-хууль сахиулах ажил” мэргэжлийн эчнээ 3 жилийн хөтөлбөрийн 2 дугаар дамжаанд дуучин, цагдаагийн ахлах ахлагч Г.Дарханбаатар суралцаж дамжаагаа амжилттай дүүргэв.

Түүнчлэн Монгол Улсын Их сургуулийн утга зохиол, урлаг судлалын магистрт цагдаагийн музей, соён гэгээрүүлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч С.Дуламсүрэн, Соёл урлагийн их сургуулийн дуурийн дуулаачийн магистрын сургалтад дуулаачийн багш, цагдаагийн дэслэгч Д.Содномдаржаа нар суралцаж байна.

Монгол Улсын Их сургуульд Сэтгэл судлалын докторын сургалтад соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг элсэн суралцаж эхлээд байна.

Мөн оны ЦЕГ-ын Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан “Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл бэлтгэл хангах сургагч багш бэлтгэх сургалтад жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Ц.Ууганбаяр хамрагдаж 2019/АГЗ-0015 дугаартай гэрчилгээ, алба хаагчийн чадамжийн сургалтад соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг хамрагдаж 2019/СБ-0084 дугаартай гэрчилгээ, Хүний нөөцийн хэлтэс, Аюулгүй байдлын хэлтсээс зохион байгуулсан “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, эрх бүхий албан тушаалтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх”, Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтны давтан сургалт”-хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Г.Алтан-Эрдэнэ хамрагдаж 2019/МС-0818 дугаартай гэрчилгээг тус тус авсан болно.

Цагдаагийн ерөнхий газрын төв архиваас зохион байгуулагдсан “2019 онд хийгдэх Улсын үзлэгт Архив, албан хэрэг хөтлөлтөд анхаарах зүйл” сэдэвт сургалтад тус чуулгын бичиг хэргийн эрхлэгч, цагдаагийн дэд ахлагч Г.Ган-Очир, Төлөвлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ч.Бадамдорж

“Алба хаагчдын чадамжийг үнэлэх, үнэлгээг баталгаажуулах нь”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт зөвлөгөөн”-д оролцов.

Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулагдсан “Авлигын эсрэг” сургалтад 7 алба хаагч тус тус хамрагдсан байна.

Уран бүтээлчдийг чадавхжуулах зорилгоор “Монгол бий биелгээ” дасгалыг СУИС-ийн бүжгийн тэнхимийн багш, “Nature dance” продакшны захирал, СТА М.Мөнгөнцэцэг 12 цагийн сургалт, Үндэсний урлагийн их театрын бүжигчин, СТА Б.Батгэрэл “Олон үндэстний дасгал”-ын дасгалыг оруулж, БНСУ-ын Үндэсний урлагийн их сургуулийн оюутан Б.Энхзулыг урьж “Орчин үеийн бүжигчдийн чиг хандлага, Шинэ үеийн манлайлал” сэдвээр лекц уншуулсан.

Алба хаагчдад орж байгаа хичээл сургалтуудаар олж авсан мэдлэгийг баталгаажуулах, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх үүднээс алба хаагчдын дунд 3 удаа “АХА” тэмцээн явууллаа.

Тус чуулгаас 3 сургалтын саналыг гүйцэтгэлийн болон соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулахаар ЦЕГ-т хүргүүлж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/19 дугаартай тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2019 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 4.5-д “Алба хаагчдаас сонгон шалгаруулж 1 алба хаагчийг “Хөтлөгч”-ийн сургалтад хамруулж мэргэшүүлэх”, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2019 оны 01 дүгээр 08-ны өдөр баталсан “Сүлд чуулгын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 4.1.6-д “Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчдын дунд 3 үе шаттайгаар “Шилдэг лектор”-ын сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах”, 4.1.18-д “Сүлд чуулгын алба хаагчдад зориулсан менежмент марктенгийн /менежер бэлтгэх/ сургалтыг тодорхой хугацаанд зохион байгуулах талаар ЦДЦСНТ-д санал тавих” зэргээр тусгагдаж батлуулсантай холбогдуулан 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 26/46 дугаартай албан бичгийг хүргүүлсэн болно.

Соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр: Тус чуулгаас Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/19 дугаартай тушаалаар баталсан 4 чиглэлээр 36 ажил, арга хэмжээ бүхий “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2019 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, Чуулгын даргын 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр баталсан 4 чиглэлээр 47 ажил арга хэмжээ бүхий “Сүлд чуулгын 2019 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж ажиллав.

Хагас жилд мэдээлэл сурталчилгааны чиглэлээр 84 удаагийн ажил, арга хэмжээг 94401 хүнийг хамруулан зохиож, 147 удаагийн соёл хүмүүжлийн ажлыг 16177 хүнийг хамруулан нийт 231 удаагийн ажлаар 110578 хүнд зохион байгууллаа.

ЦЕГ-аас баталсан төсвийн тодорхой хэсгийг өөрийн орлогоороо бүрдүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Үргэлж тантай хамт өдөрлөг”-ийг төрийн байгууллага, Төрийн өмчит үйлдвэрийн газруудад борлуулах зорилгоор Барилгын хөгжлийн төв, Дулааны II, III, IV цахилгаан станцын удирдлагуудтай уулзаж хамтран ажиллах тухай албан хүсэлтийг хүргүүлж, Дулааны II цахилгаан станцтай хамтран 2.050.000 үнэлгээ бүхий соён гэгээрүүлэх ажлыг зохион байгууллаа.

Цагдаагийн Сүлд чуулгын www.suld.police.gov.mn вэб сайт, Цагдаагийн СҮЛД чуулга / Suld Ensemble of Mongolian police олон нийтийн сүлжээний цахим хуудсанд үйл ажиллагааны мэдээллийг тухай бүр байршуулж олон нийтэд хүргэлээ.

Эхний хагас жилд чуулгын уран бүтээлчдийн 6 тоглолтыг бүрэн бичлэгийг Эко, Малчин, Өлзий телевизүүдээр хийлгэж, дуучин, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Амарболдын “Аягтай аястай хорвоо”, бүжигчдийн дан бүжгийн уран бүтээлийн

телеконцерт, дуучин цагдаагийн ахлах дэслэгч Б.Долгормаагийн “Хайрын урь” нэвтрүүлэг зэргийг Малчин, Эко, Сүлд, ETV, ТВ10, Өлзий телевизээр олон нийтэд хүргэв.

Бүжгийн багш, бүжиг дэглээч, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгар Эко телевизийн “Хөрөг” нэвтрүүлэг, Өлзий телевизийн “Миний ертөнц” нэвтрүүлэг, бүжигчид МҮОНТ телевизийн “Хүрээ донж” нэвтрүүлэг, дуучин, цагдаагийн ахлах ахлагч Г.Дарханбаатар, дэд ахлагч Ж.Үржинханд нар “Эх дэлхий радио” 107.5 FM-ын ярилцлага, дуучин, цагдаагийн дэд ахлагч Л.Эрдэнэболд ТВ1 телевизийн “Өглөөний зочин” нэвтрүүлэгт тус тус оролцов.

МҮОНТ телевизийн “Өглөө” хөтөлбөрийн тусгай дугаарт 3 дуу, 1 бүжгийн уран бүтээлээр, Монгол телевизийн “Өнөө өглөө” хөтөлбөрт чуулгын соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг, Сүлд телевизийн өглөөний ярилцлагад хөгжимчин, цагдаагийн ахлах ахлагч У.Батбаяр, Өлзий телевизийн өглөөний хөтөлбөрт дуучин, цагдаагийн ахлах ахлагч Г.Дарханбаатар, МҮОНТВ-ийн өглөө хөтөлбөр болон хөгжмийн хөтөлбөрт дуучин, цагдаагийн дэд ахлагч Л.Эрдэнэболд, хөгжимчин, цагдаагийн дэд ахлагч М.Сарантуяа, Монгол телевизийн нэвтрүүлэгт 2, Эко телевизийн “22 ток шоу”, чуулгын дарга, цагдаагийн хурандаа Л.Гаваасүрэн, дуучин, цагдаагийн ахлах дэслэгч Б.Долгормаа, Ц.Амарболд нар оролцож, уран бүтээл болон байгууллагын үйл ажиллагааг сурталчиллаа.

Соёл, хүмүүжлийн ажлын хүрээнд: Ахмад, залуу үеийн залгамж холбоог сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол Улсын Цагдаагийн байгууллагын орчин үеийн эрэлч нохойн албыг үүсгэн байгуулагч, цагдаагийн албаны үндсэн үүрэгт ажлаа амжилттай хийж бүтээхийн зэрэгцээ 1953 оноос эхлэн Цагдан сэргийлэх клубын уран сайханчаар 30 жил ажиллаж ирсэн цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Лувсан овогтой Шархүүд зориулсан "Цагдаа мартаагүй" хүндэтгэл, алдрын арга хэмжээг зохион байгуулж, Соён гэгээрүүлэх телевиз бичлэг хийж эх орон даяар цацсан болно.

Сүлд чуулгаас “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хүрээнд Хэвлэл мэдээллийн төвийн даргаар ажиллаж байсан цагдаагийн бэлтгэл дэд хурандаа З.Батсүхийг урьж ирүүлэн чуулгын бие бүрэлдэхүүнтэй уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Түүнчлэн тус чуулгаас сар шинийн баярыг тохиолдуулан өндөр настны тэтгэвэрт гарсан нийт 36 ахмад ажилтан хүндэтгэл үзүүлсэн болно.

Эрүүгийн цагдаагийн албаны түүхт 85 жилийн ой, Зэвсэгт хүчний 98 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан тус албаны нийт бие бүрэлдэхүүний дунд болон Тээврийн цагдаагийн албаны алба хаагчдын дунд “Үргэлж тантай хамтдаа” соён гэгээрүүлэх өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд алба хаагчдыг өглөө ажилдаа цуглах үеэр үлээвэр найрал хөгжмийн аялгуугаар угтан авч, халуун кофе, цай, жигнэмэгээр дайлан, алба хаагчдын дунд “Талархлын гинж” дасгалыг хийлгэн сэтгэл зүйн эерэг, таатай уур амьсгал бүрдүүлэхийн зэрэгцээ хэлтэс тус бүрээс сонгогдсон алба хаагчдын 11 гэргий нар өөрсдийн биеэр ирж албаны бие бүрэлдэхүүнд талархал, хүндэтгэл илэрхийллээ.

Эрүүгийн цагдаагийн албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж ирсэн 11 алба хаагчийн гэргий нөхөртөө зориулан захидал бичиж, өөрийн дуу хоолойг бичүүлэн дурсамжит зураг бүхий видеог бэлтгэн, өөрийн биеэр ажил дээр нь хүрч очин мэндчилгээ дэвшүүлж, захидлаа гардуулах арга хэмжээг зохион байгуулсан нь алба

хаагчдад ажил албаараа бахархах сэтгэл төрүүлэхийн зэрэгцээ амьдралын мартагдашгүй дурсамж, аз жаргалтай хормыг бүтээлээ хэмээн алба хаагчид сэтгэгдлээ илэрхийлж байлаа.

Түүнчлэн Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын цагдаагийн хэлтэстэй хамтран “Үргэлж тантай хамтдаа” соён гэгээрүүлэх өдөрлөгийг 06 дугаар сарын 24,25-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Соён гэгээрүүлэх өдөрлөгт тус хэлтсийн 86 алба хаагч, малчдын сайн дурын бүлгийн 42 гишүүн, сургуулийн 36 багш, ажилтан, 740 иргэн, нийт 904 хүнийг хамруулан зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд цагдаагийн 2 ахмад ажилтанд талархал илэрхийлж, 2 алба хаагч, 3 гэр бүлийг алдаршуулж, 1 байгууллага, 2 иргэдийн сайн дурын бүлгийн хамтын ажиллагааг сурталчлан, 10 удаагийн урлагийн хэсэгчилсэн тоглолтоор үйлчиллээ.

“Үргэлж тантай хамтдаа” соён гэгээрүүлэх өдөрлөгийн хүрээнд Тээврийн цагдаагийн албатай хамтран “Гэр бүлдээ бичих чин сэтгэлийн захидал” арга хэмжээг зохиож харьяа нэгжүүдээс ирүүлсэн 75 захидлаас 8 захидлыг шалгаруулан өөрсдийнх нь дуу хоолойгоор дуу бичлэгийн студид бичлэг хийлгэж видеог бэлтгэн ар гэрт нь хүргэж байна.

Тус чуулгаас “Цагдаагийн Ерөнхий газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 4.1.8-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчид, тэдний гэр бүлийн гишүүдийн урлагийн авьяасыг тодруулах, цагдаагийн байгууллага, алба хаагч, тэдний гэр бүлийг олон нийтэд сурталчлах зорилгоор Цагдаагийн Ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2019 оны 05 дугаар сарын 18-30-ны өдрүүдэд урлагийн наадмыг бүсчлэн зохион байгууллаа. Урлагийн наадмын I шатны шалгаруулалтыг байгууллагууд дотооддоо зохион байгуулсан бөгөөд энэ шатнаас шалгарсан алба хаагч, гэр бүлийн гишүүд нь II шат буюу зүүн, баруун, төв, говь, хангай, нийслэлийн бүсийн шалгаруулалтад оролцлоо. Удирдамжид заасны дагуу гоцлол 5 үзүүлбэрийн төрөл, “Авьяаслаг гэр бүл”-ийн үзүүлбэрүүдээр шалгаруулалтыг явуулсан бөгөөд 21 аймаг, нийслэл бүсийн 23 нийт 44 байгууллагаас 25 гэр бүлийн 50 том хүн, 39 хүүхэд, орон нутгаас 148, нийслэлээс 78 алба хаагч, гэр бүлийн гишүүд оролцлоо.

Урлагийн наадмыг зохион байгуулсан талаарх илтгэх хуудсыг ЦЕГ-ын дарга, ЦЕГ-ын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албанд 24/357, 24/358, 24/359 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлж, дүн мэдээг Цагдаагийн байгууллагын цахим хуудсанд байршуулав.

Монголын Зохиолчдын Эвлэлийн болон “Эх орны цэрэг”, “Цагаан шонхор” яруу найргийн наадмуудын “Тэргүүн байр”-ын шагналт яруу найрагч, цагдаагийн бэлтгэл хошууч Ж.Алтангэрэлийн “Цагдаа хүний хүүхдүүд” уран бүтээлийн цэнгүүнийг чуулгын байранд зохион байгууллаа.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2019 оны Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан чуулгын алба хаагчдын хүүхдүүдэд зориулсан “Эх үрсийн баяр” арга хэмжээг Үндэсний соёл, амралтын хүрээлэнгийн төв тайзнаа 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 10.00 цагаас зохион байгууллаа.

Арга хэмжээний үеэр уран бүтээлчдийн болон Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн ахлах мөрдөгч Д.Оюундаваагийн охин О.Нандин-Эрдэнэ, эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Н.Бундхоролын охин Б.Чимэгсайхан,

Дотоодын цэргийн тусгай харуулчин, цагдаагийн ахлах ахлагч Г.Ган-Эрдэнийн охин Г.Энхцацрал, Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйлчлэгч А.Ганцэцэгийн охид Л.Янжиндулам, Л.Алимаа, ЦЕГ-ын Автобаазын ерөнхий диспетчер Л.Ганчимэгийн охин М.Норжмаа, ЭХГ-ын Шүүхийн хэлтсийн жолооч Н.Магваны охин М.Оюунгэрэл зэрэг алба хаагчдын авьяаслаг хүүхдүүдийн урлагийн тоглолтыг үзэж сонирхов.

Үндэсний соёл, амралтын хүрээлэнтэй хийсэн бартерийн гэрээний дагуу 15000 төгрөгийн үнэлгээ бүхий 5 тоглоом дээр үнэгүй тоглох “Harry” багцын тасалбарыг алба хаагчид болон тэдний хүүхдүүдэд тарааж, хүүхдүүд эцэг эхтэйгээ хамт нэг өдрийг дуртай тоглоом дээрээ тоглон дурсамж дүүрэн өнгөрүүлээ.

Эцэг эхчүүдээс бэлтгэсэн нийт 51 ширхэг баярын бэлгийг хүүхдүүдэд гардуулан өгсөн болно.

Тус чуулгын болон Бүртгэл хяналтын төвийн бие бүрэлдэхүүний дунд “Цэвэр бичигтэн” тэмцээнийг 94 алба хаагчийг хамруулан зохион байгуулж дүгнэлээ. Тэмцээнийг зохион байгуулах ажлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Бичиг судлалын лабораторийн мэргэшсэн шинжээч, цагдаагийн хошууч Б.Эрдэнэ-Очир, МУИС-ийн Монгол хэл шинжлэлийн тэнхмийн багш, доктор Ч.Бямбаханд, А.Пүрэвжанцан нарыг урьж “Бичгийн хэв судлал”, “Бүх нийтийн эх хэлний боловсрол-олон улсын хэл бичгийн чадварын шаардлага” сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан чуулгын эрэгтэй алба хаагчдаас дурсгалын зураг сарнай цэцгийг гардуулан баярын мэндчилгээ дэвшүүлж, Зэвсэгт хүчний 98 жилийн ойн баярыг тохиолдуулан чуулгын эмэгтэй алба хаагчдаас “стрессгүй өдөр” уриан дор эрэгтэй алба хаагч нарт зориулан өглөөний цай бэлтгэн дайдж, тэдний дунд “Чанга шивнээ” хөгжөөнт тэмцээнийг зохион байгууллаа.

Чуулгын бүжигчид “Хилчний нэг өдөр” бүжгийн 40 жилийн ойн хүрээнд нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 10 чуулгын баг тамирчдын дунд зохион байгуулсан спортын наадамд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, “гар бөмөг”-ийн холимог төрөлд III байр, “сагсан бөмбөг”-ийн эмэгтэйчүүдийн төрөлд III байр, “теннис”-ний төрөлд бүжгийн багш, бүжиг дэглээч, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгар II байр, “шатар”-ын төрөлд бүжигчин, цагдаагийн ахлагч Ө.Ичинхорлоо II байрыг тус тус эзэлсэн.

Нийслэлийн 380 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй 330 сум, 152 хорооны аварга шалгаруулах 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, Мөрдөн байцаах албаны нэрэмжит “Уулын дугуйн аварга шалгаруулах тэмцээн”-нд тус чуулгаас анх удаа баг бэлтгэн амжилттай оролцууллаа.

Чуулгын биеийн тамир, спорт хамтлагаас алба хаагчдын дунд “сагсан бөмбөг”, “шатар”, “даам”-ны тэмцээнийг зохион байгуулж, хуваарийн дагуу долоо хоног бүрийн лхагва гаригийн өглөө 08.00-10.00 цагийн хооронд “Хүч” спорт хорооны зааланд 21 удаагийн биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийж давхардсан тоогоор 340 алба хаагчийг хамрууллаа.

Цагдаагийн музейг хөгжүүлэх чиглэлээр: Цагдаагийн музейг цахимжуулах ажлын хүрээнд чуулгын вэб сайтад байршуулах цахим танилцуулгыг цагдаагийн музей, соён гэгээрүүлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч С.Дуламсүрэн хийж гүйцэтгэсэн.

Шинэчлэн дэглэх, орчин үеийн чиг хандлагаар хөгжүүлэх ажлын хүрээнд БСШУСЯ-ны Музей хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэн, Үндэсний түүхийн музейн Мэргэжил арга зүйн төвийн дарга, Ph.D, дэд профессор Д.Бумаа, БХЯ-ны

“Дуулга” студийн захирал, музей судлаач, дэд хурандаа Б.Гантөмөр, Монгол цэргийн музейн Эрдэм шинжилгээний ажилтан, түүхч Ж.Одонтуяа, СУИС-ийн Соёлын дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч Г.Мяндас нараас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авсан. Үндэсний түүхийн музейн Мэргэжил арга зүйн төвийн дарга, Ph.D, дэд профессор Д.Бумаа, арга зүйч Д.Эрдмаа, эрдэм, шинжилгээний ажилтан Д.Мөнхтоогоо нараас зохион байгуулсан “Музейн үзмэрийн тайлбар, танилцуулга”, Музейн үзмэрт тулгуурласан боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй”, “Бөс даавуун эд өлгийн зүйлийг дэглэх арга зүй” сургалтад хамрагдлаа.

Нийслэлийн 31 дүгээр сургуулийн 41 сурагч, тус чуулгын 62, ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвийн 35, нийт 134 алба хаагч, ажилтнуудад музейгээр үйлчилж алба хаагч, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулав.

ЦЕГ-ын Хэвлэл, мэдээллийн төвөөс эрхлэн гаргадаг “Цагдаа” сэтгүүл”-ийн 2019 оны I,II улирлын дугаарт “Цагдаагийн музейд тавтай морил” нийтлэлийг хүргүүлэв.

Цагдаагийн байгууллагаас 2006 оноос эхлэн Олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үүрэг гүйцэтгэсэнийг сурталчлах ажлыг санаачилж, энэ чиглэлээрх мэдээ, мэдээллийг багтаасан булан байгуулж, цагдаагийн музейн сан хөмрөг, үзмэрийг баяжуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан Баянгол дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Ганбаатар, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн систем хариуцсан инженер, цагдаагийн ахмад Б.Долгормаа нарт талархал илэрхийлэн дурсамж хадгалуулав.

Их танхимд ЦДЦ-ийн анги байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, ЕБ-ийн болон их дээд сургуулийн нийт 37 арга хэмжээ, ТВ 4 бичлэг зохион байгуулагдаж ЦДЦ-ийн байгууллагын 3700 алба хаагч, 2350 иргэд, 310 оюутан, 1100 сурагчид зэрэг нийт 8700 гаруй хүн үйлчлүүлсэн байна.

Уран бүтээлийн чиглэлээр: 2019 оны уран бүтээлийн нэгдсэн төлөвлөгөө, дуу, хөгжим, бүжгийн хэсгийн I,II улирлын төлөвлөгөөг чуулгын даргаар батлуулж, чуулгын уран сайхны зөвлөлийн хурлыг 9 удаа хийж, чуулгын уран сайхны бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллав.

БСШУСЯ-ны Урлаг дэмжих сан, Швейцарын хөгжлийн агентлагаас зарласан Соёл урлагийг дэмжих төсөл шалгаруулах шалгаруулалтад “Шилмэл бүтээл” төсөл бичиж хүргүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас ирүүлсэн 104 хүсэлт, албан бичгийн дагуу олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах аян, арга хэмжээний хүрээнд 28, хүндэтгэлийн болон, нээлт, шав тавих ёслолын 27, баяр ёслол, тэмдэглэлт өдрийн хүрээнд 14, улсын болон олон улсын хурал, уулзалт зөвлөгөөний зочид, төлөөлөгчдөд 4, төрийн одон медаль, шагнал гардуулах ажиллагаанд 7, хэвлэл мэдээллийн байгууллагын 7, “Үргэлж таньтай хамтдаа” соён гэгээрүүлэх өдөрлөгт 2, хандивын тоглолтод 3, нас барсан алба хаагчидтай салах ёс гүйцэтгэх ажиллагаанд 4, нийт 104 үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцож энэ хугацаанд бүрэн хэмжээний 11, хэсэгчилсэн 93 урлагийн тоглолтоор 15000 гаруй алба хаагч, иргэдэд үйлчилсэн байна.

Хөгжимчид дан хөгжмийн 10, дуулаачийн 13, нийт 23 зохиол бүтээл гаргаж, бүжигчид 19 шинэ уран бүтээл дээр ажиллаж, 2 бүрэн хэмжээний бүжгийн жүжгийн тавилт хийж, дуучид шинээр 21 уран бүтээл хийж, 4 уран бүтээлийг сэргээн дуулж, цөөхүүл 3, нэгдсэн 1, нийт 29 уран бүтээлийг урын санд нийлүүлсэн байна. Чуулгын урын санг эхний хагас жилд давхардсан тоогоор 73 уран бүтээлээр баяжууллаа.

Мөн дуучин, СТА, цагдаагийн ахлах ахлагч Г.Дарханбаатар “Жаргалын цэцэг”, СТА, цагдаагийн ахлах дэслэгч Б.Долгормаа “Үлэмж яруу”, дуучин, цагдаагийн ахлах ахлагч Э.Нямхүү “Сайхан хүмүүс” зэрэг уран бүтээлийн 3 цомог гаргаж, дуучин, СТА, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Амарболдын “Аягтай аястай хорвоо”, бүжигчдийн “Хан уялага” дан бүжгийн уран бүтээлийн теле концертийг хийж 7 телевизээр цацагдаж, 8 телевизэд уран бүтээлүүд бичигдэн олон нийтэд хүрэв.

2019 оны 05, 06 дугаар сард өгөгдсөн уран бүтээлийн даалгаварыг анги тус бүрээр чуулгын дарга тэргүүтэй уран сайхны зөвлөл үзэж чуулгын урын санд нийлүүлэх, баяжуулах ажлын хүрээнд биелэлтийг шалгахад 7 дуучны 11 уран бүтээлийн 5 дуу шаардлага хангаж, бүжиг ангийн 6 гоцлол бүжгийн уран бүтээлээс 2 бүжгийг урын санд нийлүүлэх, хөгжим ангийн дан хөгжмийн зохиол 2, цөөхүүл хөгжмийн бүтээл 3, “Ялалтаар цэлмэсэн тэнгэр” маршийн зохиолуудыг урын санд оруулахаар шалгаруулж цаашид тоглолтуудад нийлүүлж ажиллах боломжтой үнэлгээг өгсөн байна.

Хагас жилийн хугацаанд чуулгын уран бүтээлчид мэргэжлийн уран чадвараа сорин улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцож ирлээ.

Тухайлбал, ХБНГУ-ын Штутгарт хотод зохион байгуулсан модерн бүжгийн ОУ-ын уралдаанд бүжгийн багш, дэглээч, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгар өөрийн дэглэсэн “Би Монгол хүн” бүтээлээр оролцож шилдэг 6-д үлдэж, Дуурь бүжгийн эрдмийн театрын “Номадик” продакшнаас зохион явуулдаг балетын, болон модерн бүжгийн улсын уралдаанд бүжгийн багш, бүжиг дэглээч /туслах найруулагч/ СТА, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгарын дэглэсэн 4 бүжгээр оролцож, бүжигчин, цагдаагийн ахлагч Э.Жаргалмаа II байр, цагдаагийн ахлагч А.Эрдэнэбаяр III байр, балетын төрөлд Б.Ууганбилэг II байрыг эзлэв.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан 12 орны уран бүтээлчид, ардын авьяастнууд оролцсон “Азийн ардын урлагийн их наадам”-ын ардын бүжгийн төрөлд нийт 596 бүжигчин оролцож, чуулгын эрэгтэй бүжигчид цөөхүүл бүжгийн төрөлд бүжгийн багш, бүжиг дэглээч МУСТА, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгарын дэглэлт “Товшуурт торгууд” бүжгээр “Тэргүүн” байр эзэлж, дэлхийн аваргад оролцох эрхийг авлаа.

Чуулгын дуучин, Ж.Хулан, хөгжимчин, цагдаагийн дэд ахлагч М.Сарантуяа нар “Монгол HD” телевизийн “The Voice” тэмцээний 2 дугаар шатны шалгаруулалтад тэнцэж, урилгаа гардан авлаа.

ОХУ-д зохион байгуулагдах П.И.Чайковскийн нэрэмжит олон улсын дуурийн дуулаачдын уралдааны сүүлийн шатанд тус чуулгын дуучин, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Амарболд тэнцэж, Олон улсын шилдэг 30 дуучны эгнээнд багтав.

Хөгжимчин, цагдаагийн ахлах ахлагч У.Батбаяр “Чандмань тамга” бие даасан уран бүтээлийн тайлан тоглолт, дуучдын “Монгол минь амгалан байна” нэгдсэн тоглолт, дуучин, цагдаагийн ахлах дэслэгч Б.Долгормаагийн “Хайрын урь” уран бүтээлийн анхны бие даасан тоглолт, чуулгын шилмэл уран бүтээлийн “Хачин гоё” нэгдсэн тоглолт, ялалтын баярыг угтан “Великая победа” тоглолтуудыг амжилттай зохион байгууллаа.

Тус чуулга нь цагдаагийн байгууллага болон чуулгын уран бүтээлчид, тэдний уран бүтээлийг олон нийтэд таниулан сурталчлах, уран бүтээлийн хомсдолоос сэргийлж, урын сангаа баяжуулах, шинэ уран бүтээлийн зардал олох зорилготой

“Хачин гоё” тоглолт 2019 оны 04 дүгээр сарын 19-ний 19.00 цагт Улаанбаатар паласын концертийн их танхимд амжилттай зохион байгуулав.

Уран бүтээлийн нэгдсэн тоглолтыг зохион байгуулах ажлын хэсгийг чуулгын даргын 2019 оны А/05 дугаар тушаалаар байгуулж, тоглолтын нэгдсэн төлөвлөгөө, бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Тоглолтыг зохион байгуулалттайгаар үзүүлэх тухай чиглэлийг Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2019 оны 5/94 дугаартай албан бичгээр Улаанбаатар цагдаагийн хүрээний цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт мөн дарга нар өөрсдөө гэргийн хамт заавал үзэхийн зэрэгцээ урилга хүлээн авсан хөдөлмөрийн тэргүүний болон ажил мэргэжлийн аварга алба хаагч онцлох ажилтнуудыг гэр бүлийн хамт уг тоглолтыг үзэх боломжоор хангаж өгөх тухай чиглэлийг цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа З.Дашдаваа даргын гарын үсэгтэй албан бичгээр тус тус хүргүүлэв.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад уг тоглолтыг харъяа агентлагуудын төрийн албан хаагчдыг зохион байгуулалттайгаар үзүүлэх талаар дэмжлэг үзүүлж өгөх тухай албан бичиг хүргүүлж, ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн харъяа агентлаг байгууллагуудад албан бичгийг хүргүүлэн дэмжиж ажилласан.

Тоглолтыг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах үүднээс МУ-ын филармоний утсан болон цохивор хөгжимчин 2, морин хуурч 1, лимбэчин 1, утсан хөгжим 14, бүжигчин 2-ыг тус тус гэрээгээр ажиллуулан хөг нэмж, Нийслэлийн соёл урлагийн газраас нэмэлтээр 8 ширхэг хавчдаг микрофони, 7 микрофонийн хөл, 3 микрофони гаднаас авч ашигласан болно. СУИС, ЦДБЭЧ-аас бүжигчдийн хувцсыг түрээсэлж, шаардлагатай жижиг хэрэглэлийг чуулгуудаас татаж ажилласан.

Тоглолтын сурталчилгааны 42 секунтын видео шторк, 1 минут 16 секунтын радиогийн шторкийг “Мэлмий” студитэй хамтран бүтээв.

Тоглолтын сурталчилгааны видеог UBS, TB8, TV5, Сүлд, Royal, ECO, Суваг 1, ETV, Малчин, Соён гэгээрүүлэгч зэрэг 10 телевизээр 04 дүгээр сарын 8-наас 19-ний өдрийг хүртэлх хугацаанд өдөрт 8-10 удаагийн давтамжаар гаргасан.

Мөн Авторадио 96.3, Best FM 98.5, Их Монгол 99.6, Инээмсэглэл 99.3, Kiss Fm 100.1, Лавайн эгшиг, Улаанбаатар FM 102.5, Хамаг Монгол 95.1, Шинэ долгион 107.5, Шинэ Монгол 101.7 зэрэг 10 радиогоор өдөрт 8-14 удаагийн давтамжаар 8 өдөр тасралтгүй сурталчилсан болно.

Уг тоглолтын реклам сурталчилгааг Нарантуул худалдааны төвийн “Баялаг ундраа” худалдааны төвийн гадна байрлах лед дэлгэц, Сүхбаатарын талбайн урд байрлах “Нийслэл дэлгэц”-ээр өдөрт 30-40 удаагийн давтамжаар 300 орчим удаа цацагдсан.

Тоглолтыг угтаж чуулгын уран бүтээлчид болон тэдний уран бүтээл, тоглолтыг сурталчлах ажлын хүрээнд 5 телевизтэй хамтран ажиллах гэрээг шинээр байгуулж, MN25 дугаар суваг телевизийн Бон-апетит нэвтрүүлэгт 1, ТВ8 телевизийн ярилцлагын цагаар 2, Монгол HD телевизийн “Өнөө өглөө” хөтөлбөрт 2, Сүлд телевизийн “Сүлд өнөөдөр” хөтөлбөрт 4, “Би уран бүтээлч” нэвтрүүлэгт 1, Royal телевизийн “Өдрийн хөтөлбөр”-т 2, “Му UB” нэвтрүүлэгт нийт уран бүтээлчид, Өлзий телевизийн “Энх өглөө” хөтөлбөрт 1, ECO телевизийн “22 ток шоу”-нд 6, 1 дүгээр суваг телевизийн “Өглөөний хөтөлбөр”-т 1, “Амьдрах ухаан” хөтөлбөрт 1, нийт 8 телевизийн 14 хөтөлбөр, нэвтрүүлэгт 21 уран бүтээлчийг оролцууллаа.

Тоглолтын талаарх товч мэдээлэл, сурталчилгааны зурагт хуудсыг zindaa.mn, breakingnews.mn, ikon.mn, zaluus.com, serelt.mn вэб сайтуудад байршуулав.

Чуулгын фэйсбүүк цахим хуудсанд тоглолтын 4 төрлийн шторкийг байршуулав. Фэйсбүүк хуудас болон тоглолтын шторкийг төлбөртэйгээр илүү олон хүнд хүргэх идэвхжүүлэлтийг хийж, идэвхжүүлэлт хийснээс хойш хуудсыг дагагчдын тоо 3 дахин нэмэгдэж, зөвхөн тоглолтын 4 төрлийн шторкийг 93 мянган хүн үзэж 845 хүн бусдад хуваалцаж, 1062 хүн эерэг хариу үйлдэл үзүүлсэн байна.

Тоглолтын үеэр Соён гэгээрүүлэгч, Малчин телевиз бүрэн бичлэгийг хийж, МҮОНТВ-ийн Урлаг теле сэтгүүл, Сүлд, Өлзий телевиз, Зиндаа.мн, Өглөөний сониноос тоглолтын онцлог, явцын талаарх мэдээ сурвалжлага бэлтгэн чуулгын дарга, уран сайхны удирдагч болон давхардсан тоогоор нийт 16 уран бүтээлч ярилцлага өглөө.

Тоглолтын урилгыг яамны газрын дарга, харъяа агентлагуудын дарга нарт гэр бүлийн хамт, цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын дарга нарт гэр бүлийн хамт, ЦЕГ-ын Хөдөлмөрийн болон ажил мэргэжлийн аваргууд, онцлох 26 алба хаагчдад гэр бүлийн хамт, СААА-ны бүх нягтлан бодогч, нярав, Нийслэлийн цагдаагийн газрын ахмадын хороо, чуулгын ахмадууд ажилчид, алба хаагчдад урилгаар тоглолт үзүүлсэн болно.

“Хачин гоё” тоглолтын билетийн орлогыг 70 хувьтай төвлөрүүлэв.

Гурав. Санхүү, бүртгэл, санхүү хангамж, үйлчилгээ, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах талаар

2019 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар тус чуулгад улсын төсвөөс 317,9 сая төгрөгний төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 317,9 сая төгрөг, өөрийн орлогоос 11,2 сая төгрөг орж бүгд 329,1 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэртэй ажиллалаа.

Сангийн Сайдын 2002 оны 191 тоот тушаал, Сангийн Сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалаар баталсан анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн маягыг хөтлөх аргачлалын дагуу ажил гүйлгээ бүрийг хөтлөн, нягтлан бодох бүртгэлд тусган тайлан тэнцлийг хуулийн хугацаанд гаргаж Санхүү аж ахуйн албанд хүргүүлэв.

Тус чуулгын данс бүртгэлгүй эзэмшиж байсан 1 газар, дулаан болон цэвэр усны 1 шугам, 1 барилгад үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн.

Шилэн дансны мэдээллийн сар бүрийн 8-ны өдөрт багтаан нийт 16 маягтын дагуу тайланг оруулж, цахимд хуудсанд байршуулсан.

Мөн алба хаагчдыг “хуримтлал бий” болгох ажлыг зохион байгуулж нийт 19 алба хаагчдад шинээр хуримтлалын данс нээлгэж, хуримтлалын данстай алба хаагчдын гэрээг нь шинэчлэв.

2019 оны 1 дүгээр улиралын санхүүгийн тайлан балансыг гаргаж, 2019 оны 03-р сарын 10 ны өдөр, Санхүү аж ахуйн албаны ахлах мэргэжилтэн цагдаагийн дэд хурандаа Д.Бат-Оюунд шалгуулж, тус албаны ахлах мэргэжилтэн цагдаагийн ахмад Б.Энхтуяагаар тайлангийн нэгтгэлд нэгтгүүлсэн.

Шилэн дансны мэдээллийн сар бүрийн 8 ны өдөрт багтаан нийт 16 маягтын дагуу тайланг оруулан цахимд хуудсанд байршуулсан. Нийт 5-р сарын байдлаар давхцсан тоогоор 65 мэдээллийг оруулсан.

Баянзүрх дүүргийн онцгой байдлын хэлтсээс байгууллагын галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулж авсан.

Дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд байгууллагын гадна талд 1 ширхэг, дотор зоорийн давхарт 2 ширхэг хяналтын камер нэмж суурилуулсан.

Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны “Миний зөвлөгч” өрхийн эрүүл мэндийн төвтэй халдвар болон халдварт бус өвчлөлүүдээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтарч ажиллах гэрээ байгуулсан.

ЦЕГ-ын САА албаны даргаас ирүүлсэн “Эрүүл цагдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд чуулгын нийт алба хаагч, ажилтнуудыг элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээ, дархлаажуулалтын вакцин, эмчилгээ сувилгаанд бүрэн хамруулах зорилгоор Евростандарт эмнэлзүйн лабораторийн эрхлэгч, ажилтан нар 2019 оны 03 дугаар сард чуулгын 49 алба хаагчийг хамруулан элэгний хавдарыг үүсгэгч В, С вируст гепатит өвчний талаар товч мэдээллийг хийж үнэ төлбөргүй шинжилгээнд хамрууллаа.

ХБНГУ-н брэнд БНХАУ дахь “KLEIMAN” хөгжмийн үйлдвэрээс 20 нэр төрлийн 46.000.000 сая төгрөгийн үнэ бүхий үлээвэр хөгжмийн зэмсгийн үнийн судалгааг хийж, ЦЕГ болон БСШУСЯ-ны сайдад явуулсан.

ОХУ-д зохион байгуулагдах П.И.Чайковскийн нэрэмжит олон улсын дуурийн дуулаачдын уралдаанд оролцох тус чуулгын дуучин, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Амарболд, концертмейстр Т.Энхтуул, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн харуулчин /дуучин/, дэд ахлагч Б.Жавхлантөгс нарын ОХУын САанкт-Петербург хотод зорчих, байрлах үеийн зам, хоног болон хоолны зардлыг шийдвэрлүүлэх талаар ЦЕГ-ын даргад албан бичгээр хүсэлт илгээж шийдвэрлүүлсэн.

ЦЕГ-ын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/121 дугаар тушаалаар цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй “Эрүүл цагдаа хөтөлбөр”-ийн хүрээнд алба хаагч, ажилтны мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг хийх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд тус чуулгын 55 алба хаагчийг 7 төрлийн үзлэг шинжилгээнд хамруулав.

Дөрөв. Дотоод хяналтын хүрээнд

Сүлд чуулгын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж чуулгын даргаар батлуулсан.

ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын даргаас ирүүлсэн ЦЕГ-ын даргаас удирдах ажилтны зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, Сэтгэл зүйн судалгаа шинжилгээний тайлан, өгсөн ажлын чиглэл, МДШШУА-аас ирүүлсэн зөвлөмж, АБХ-ийн даргаас ирүүлсэн ЦЕГ-ын дэд даргаас удирдах ажилтны зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, ажлын чиглэлийг алба хаагчдад танилцуулж ажиллав.

ЦЕГ-ын дэд даргаас ирүүлсэн ЦЕГ-ын “Төв байрны дотоод журам” –ыг судлуулах тухай үүрэг ажлын чиглэл, Хуулийн хэлтсийн даргаас ирүүлсэн ЗГ-ын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний алба хаагчийн ёс зүйн дүрэм”- ийг судлуулах үүргийн дагуу алба хаагчдад танилцуулав.

Төлөвлөлт, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтнээс өглөө бүр алба хаагчдыг бүртгэж ажлын цаг ашиглалтад хяналт тавьж ажлаас хоцорсон алба хаагчдад сануулга бичиж алдаа дутагдлаа засах, ажлын өдрийн цаг ашиглалтыг сайжруулах, цагийг зөв зохистой үр дүнтэй, бүтээлчээр өнгөрөөх, ажлын байрны

буюу ерөөний цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, ажлын цагийн хуваарийг хийж батлуулах талаар үүрэг чиглэл өглөө.

Нэгдүгээр сараас эхлэн чуулгын даргын өгсөн үүргийн дагуу алба хаагчид даваа гаригийн өглөөний нэгдэлтэнд өдөр тутмын хувцастай бусад өдөр ажлын цагаар албаны ноосон цамцтай буюу дүрэмт хувцастай ажил үүргээ гүйцэтгэж хэвшсэн.

Чуулгын жижүүрийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын чиглэл өгч үйл ажиллагааг шалган жижүүр дээр хөтлөгдвөл зохих бичиг баримтуудыг шалгаж ажилласан.

Алба хаагчдын хаягийн бүртгэлийг шинэчлэн батлуулж, чуулгын өрөө тасалгаануудын лац хүлээн авах дэвтрийг шинэчилсэн.

“Сар шинэ-2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 25 алба хаагч 2019 оны 01 сарын 31, 02 дугаар сарын 01, 02 -ны өдрүүдэд эргүүлийн үүрэг гүйцэтгэв.

Монгол түмний уламжлалт баяр, Арван долоодугаар жарны “Урвуулагч” хэмээх шороон гахай жилийн сар шинийн баяр, амралтын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/49 дугаар тушаалаар Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын 2 дугаар зэрэглэлд шилжүүлэх тухай тушаалын дагуу чуулгын даргын 2019 оны А/01 тоот тушаалаар баяр амралтын өдрүүдэд ажиллах ерөнхий эргүүл, жижүүрээр үүрэг гүйцэтгэх алба хаагчдын томилгоог хийж чуулгын даргаас 9 төрлийн үүрэг чиглэл өгч, баталгаа авч, 7 офицер, 4 ахлагч нийт 11 алба хаагч хариуцлагатай эргүүл, жижүүрийн үүргийг зөрчил дутагдалгүй гүйцэтгэсэн.

ЦЕГ-ын даргын 2017 оны А/246 тоот тушаалаар батлагдсан Цагдаагийн дотоод албаны дүрэм ЦБҮАЖ /код 101/-ийг хэрэгжүүлэх, чуулгын бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдлыг дээшлүүлэх, “Цугларах” дохиогоор ажиллах дадлага олгох зорилгоор 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 06:30 цагт Чуулгын даргын баталсан удирдамжийн дагуу “Цугларах” дохиогоор ажиллуулахад ЦБҮАЖ /код 101/-ийн 8.3-ийн “а” заасан хугацаанд /1 цаг 30 минут/ нийт 49 алба хаагч цугларахаас 31 алба хаагч хугацаандаа цугларч, 5 алба хаагч хоцорч, 7 алба хаагч ирээгүй болно.

Цугларах дохиогоор ажиллах удирдамжид заасны дагуу алба хаагчдын албаны үнэмлэх, энгэрийн тэмдэг, албаны дүрэмт хувцас, аранзны үзлэгийг явуулсан бөгөөд “цугларах” дохиогоор ажилласан байдлын талаар чуулгын даргад илтгэх хуудсаар танилцуулсан болно.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН СҮЛД ЧУУЛГА